



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДҮГНЭЛТ

2025 оны 12 сарын 16-ны өдөр

Дугаар 01

Баян-Өндөр сум

,,, А.....-ын ёс зүйн асуудлаар ирүүлсэн гомдлыг
шалгасан тухай

Удиртгал: Иргэн Д.А.....-аас аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн мэргэжилтэн ... А.....-ын харилцаа хандлага, ёс зүйд холбогдуулан ирүүлсэн гомдлыг шалгаж аймгийн ЗДТГ-ын Ёс зүйн дэд хорооны дарга О.Санжмятав, гишүүн М.Бямбадорж, Л.Дуламжав, Б.Цэрэннадмид нарын бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 15 цагт аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд хуралдаж хэлэлцэн дараах дүгнэлтийг гаргав. Хуралдааны тэмдэглэлийг Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Б.Цэрэннадмид хөтлөв.

Тодорхойлох нь: Иргэн Д.А..... нь БОНХОБТХ-ийн мэргэжилтэн ..А.....нь миний өгсөн бичиг баримтыг хавтсанд хийж өгөөгүйгээс алга болбол би хариуцлага хүлээхгүй, өрөөнөөс гар гэх зэргээр чанга дуугаар ёс бус харьцсан тул Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуульд зааснаар хариуцлага тооцож өгөхийг хүссэн.

Үндэслэх нь: Булган аймгийн иргэн Д.А.....-аас БОНХОБТХ-ийн мэргэжилтэн ... А.....-ын ёс зүйн асуудлаар ирүүлсэн гомдлын дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүн М.Бямбадорж шалгалаа. Энэхүү гомдол нь “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийн 8.1.1 дэх хэсэгт хамаарах гомдол байна. Гомдлын дагуу шалгалт хийхдээ “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” -ыг удирдлага болгон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйл /“Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх”/-д заасны дагуу ажиллаж гомдолд холбогдохА.....-аас тайлбарыг бичгээр гаргуулан авч, иргэн Д.А.....-тай 2025 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 16.05 цагт гомдол гаргагчийн 80079686 дугаарын утсаар холбогдож нэмэлт тодруулга авч тэмдэглэл хөтөлж ажилласан.

- БОНХОБТХ-ийн мэргэжилтэн...А.....-ын өгсөн тайлбарт: “Тухайн үед аймгийн Засаг даргын 2025 оны 08-р сарын 28-ний өдөр А/711 дугаар захирамж гарсантай холбогдуулан баримт бичгийн бүрдэлийг хяналтын инженерээс авах, баримт бичиг хүлээлгэн өгөх ажлыг ч мөн хяналтын инженер хариуцаж байгаа талаар хэлсэн бөгөөд тус иргэнтэй холбогдон хариу өгсөн” гэсэн байна.

- Иргэн Д.А.....-аас авсан нэмэлт тодруулгад: “...Би Булган аймагт оршин суудаг, “Гурван уулын хишиг” ХХК-ийг төлөөлж мэргэжилтэн ...А.....тай анх удаа албан шугамаар өрөөнд
уулзсан.
..... нь

..... Гэвч .А..... гэдэг мэргэжилтэн төрийн ажил, иргэдэд үйлчлэх ажил хийж байж арга зүйн зөвлөмж хэлэхийн оронд маш дээрэнгүй харилцаж, асуулт асуухад хариулахгүй, материалаа уутанд хийж өг, алга болговол би хариуцахгүй шүү, миний өрөөнөөс гар гэх зэргээр бүдүүлэг үг хэллэгээр доромжилсонд гомдолтой байна” гэсэн байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг "төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил" гэж үзнэ гэж заасан.

...А..... нь иргэний гомдолд дурдагдсан процесс, үйл явдал болсон эсэх асуудлыг үгүйсгээгүй байна

Дээрх нэмэлт тодруулга, тайлбар зэргээс үзэхэд мэргэжилтэн М.Алтангэрэл нь иргэнтэй харилцахдаа ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэхээр байна.

Дүгнэлт: Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн мэргэжилтэн ...А.....нь иргэний тавьсан хүсэлтэд анхааралтай хандаж хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх шаардлагыг хэрэгжүүлэхдээ харилцааны доголдол гаргаж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1.1. -д заасан шаардлагыг зөрсөн байна гэж дүгнэв.

Аймгийн ЗДТГ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүн М.Бямбадоржийн гомдлыг шалгасан тухай танилцуулга, БОНХОБТХ-ийн мэргэжилтэнА..... -аас бичгээр гаргасан тайлбар, гомдол гаргагч иргэн Д.А.....-аас авсан нэмэлт тодруулгын талаар тэмдэглэсэн тэмдэглэл зэргийг хавсаргав.

ДАРГА

О.САНЖМЯТАВ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ЦЭРЭННАДМИД